



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/160

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн "Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 06 дугаар тогтоол, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Боловсролын салбарыг дэмжих арга хэмжээний зардлаас "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Улаанбаатар хотоос сумын Ерөнхий боловсролын сургуульд бага ангийн багшаар шилжин ирж, ажиллаж байгаа багш Сүхбатын Ганчимэгийн амьдарч буй байрны түрээсийн төлбөрт 2,100,000 төгрөгийг зарцуулсугай.

2.Арга хэмжээний төсвийн дагуу 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.С.Ганчимэгийн түрээслэж буй байрны ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Буяндэлгэр)-т, гэрээ байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг багш (С.Ганчимэг)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА